



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.28 № 02/34 ЧАТ-САТ/2014/06/СТИА-ТНЭС

Зөрчил арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Транс сэргэлт ТӨҮГ-ын 2012 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн журналаас бусад тооцооны данс утсаны улмаас 2013 оны эхний үлдэгдлийг аудитаар баталгаажуулах боломжгүй болсон, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 60.9 сая төгрөгийн авлага бүртгэгдэж байгаагаас 27.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 10.6 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 25.5 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан зэрэг зөрчлийн улмаас тус газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар “хязгаарлалттай” дүгнэлт өгөгдсөн,
- Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ын хэрэглэж буй түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлыг БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс төлж байгаа нь зардлын гүйцэтгэл, санхүүгийн үр дүн бодитоор илэрхийлэгдэхгүй байгаа, санхүүгийн тайланд нийт 12,393.0 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор, 12,110.6 сая төгрөгийг урьдчилан гарсан зардлаар бүртгэж тайлагнасан,
- Тус газар 2013 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр байгуулагдсанаас хойш бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл нь 2 удаа өөрчлөгдсөн байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг бүртгүүлээгүй, байгууллагын дүрмийг шинэчилж батлаагүй, үйл ажиллагааны чиглэл, хэтийн төлөв тодорхой бус зэрэг шалтгааны улмаас тус газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн,
- Монгол цэрэг констракшн ТӨҮГ "Круз Интернэйшнл" ХХК-ийн дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалтаас буцаан авсан 200.0 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын хэсэгт бус нийт орлогод тусгаж тайлагнасан, жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэлийн дүн Санхүүгийн тайлан, гүйлгээ балансын үлдэгдэл дүнгээс 251.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгийн дансдын элэгдлийн тооцооллыг хийгээгүй,

Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисдэг тэрэгний засварын зардлын 193.0 сая төгрөгийг орлогын тайланд үйл ажиллагааны зардлаар тайлагнасан,

- Мөн гүйлгээ балансад стандарт бус үлдэгдэлтэй данс нийтлэг, эдгээрийн үлдэгдэл санхүүгийн тайлантай тохирохгүй, касс харилцахын гүйлгээнээс бусад ажил гүйлгээг санхүүгийн програмаар гүйцэтгэдэггүй зэрэг зөрчил дутагдал илэрч, улмаар 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар “сөрөг” дүгнэлт өгөгдсөн байна.

Дээр дурдсан зөрчил дутагдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.4, 19.1.5, 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.1.7-д заасан заалтуудыг зөрчиж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, 28 дугаар зүйлийн 28.1-д “...санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасан заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн Албан шаардлага өгч байна. Үүнд:

1. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар “хязгаарлалттай” санал дүнэлт авсан Транс сэргэлт, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ууд, “сөрөг” дүгнэлт авсан Монгол цэрэг жуулчин ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулахыг Төрийн нарийн бичгийн дарга З.Болдбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Батсүх нарт даалгав.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР



Г.ЮРА